



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№25 /469/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2023.02.03

Цаг үе, үйл явдал

“БААТАРЛАГ ҮЙЛСТЭН” НОМИНАЦИД ДЭД ХУРАНДАА Н.ГЭРЭЛБАДРАХ ДЭВШЖЭЭ



МОНГОЛЫН ММ БНӨСУ-д үүрэг гүйцэтгэсэн 11 агентлагийн “Цагийн хурд” хөтөлбөр Монгол түмний их баяр Цагаан сарыг тохиолдуулан жил бүр оны “Баатарлаг үйлстэн”-ийг тодруулдаг уламжлалтай.

Түгвэл Батлан Монголын мэдээ сувагт хамгаалах салбар, Зэвсэгт хүчнээс Усан бар жилийн “Баатарлаг үйлстэн” номинацид

ММ дүгээр ээлжийн Мотобуудлагын батальоны ажиллагааны ахлах офицер дэд хурандаа Н.Гэрэлбадрахыг дэвшүүлжээ.

Түүний талаар МNB Монголын мэдээ сувагт байршсан ярилцлагыг хүлээн авч үзээд уг мэдээнд лайк дарж дэмжих боломжтой юм.



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-9	-27

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
40	23

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,509	3,512
EUR	3,830	3,850
CNY	519	522
RUB	48.60	48.90
JPY	27.20	27.40
KRW	2.86	2.88

ЗУРХАЙ



2023.02.03 /БААСАН ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 13

ӨВЛИЙН АДАГ ХАРАГЧИН ҮХЭР САР
ЕСӨН УЛААН МЭНГЭТЭЙ ХАР ЛУУ ӨДӨР

Үс засуулбал:
ЖАРГАЛ ИРНЭ
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
08.19-17.53
Барилдлага:
Үл тохирох
Шүтэн барилдлага:
Тийн мэдэхүй

“АМНЫ ХӨНДИЙН ЭРҮҮЛ МЭНД” АЯНЫГ ЯВУУЛЖ БАЙНА



Амны хөндийн эрүүл ахуй нь нэг талаас гоо сайхны асуудал мэт боловч нөгөө талаас биеийн ерөнхий эрүүл мэндэд нөлөөлөгч томоохон хүчин зүйл болдог. Нас залуу байхын хэрээр эрүүл мэнддээ анхаардаггүй, энэ талын мэдлэггүй байгаагийн улмаас хорт хавдар, зүрх судас, бэлгийн сулрал, амьсгалын замын өвчнөөр өвчилж буй залуучуудын тоо жил ирэх бүр нэмэгдэж буйг эмч нар анхааруулж байна.

Эр цэргийн албанд татагдан ирсэн залуучуудын 80-85 хувь нь амны хөндийн ямар нэг өвчлөлтэй буюу 2-3 шүд цоорсон, ёзоор үлдсэн, үрвэссэн зэрэг шалтгаантай байна. Үүнтэй холбогдуулан Зэвсэгт хүчний Жанжин штабын Эрүүл мэндийн хэлтсээс Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудад жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Амны хөндийн эрүүл



мэнд” аяныг он гарсаар хэрэгжүүлж эхэллээ.

Тухайлбал, Зэвсэгт хүчний 120 дугаар ангид 1 дүгээр сарын 31-ний өдрөөс эмчилгээ, оношилгоог эхлүүлсэн бөгөөд Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн шүдний эмч О.Насандэлгэр, Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн шүдний эмч Б.Сувд-Эрдэнэ, Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн шүдний эмч Э.Долгоржав нар

ажиллаж байна.

Томилгоот эмч нар хугацаат цэргийн хаагчдын амны хөндийн эрүүл мэндийн үзлэг, эмчилгээнээс гадна байнгын бүрэлдэхүүнд “Амны хөндийн өвчлөл үүсгэдэг эрсдэлт хүчин зүйл”, “Амны хөндийн өвчлөлөөс урьдчилан сэргийлэх”, “Шүд цоорох шалтгаан”, “Шүдийг хэрхэн зөв угаах вэ” зэрэг сэдвийн хүрээнд сургалт зохион байгуулж байна.

АРДЫН ИХ ХУРЛЫН ДЕПУТАТУУДАД ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ

Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдсаны 31 жилийн ойг тохиолдуулан тус хуулийг батлалцсан Ардын их хурлын депутатуудын төлөөлөл болох Б.Батсайхан, Д.Лонжидсүрэн, Я.Пүрэвдорж, Ч.Цэрэндагва, Д.Энхбаатар нарыг Батлан хамгаалах салбарын удирдлагууд хүлээн авч уулзан “Үндсэн хуулийн эх сурвалж” номыг гардууллаа.

Тус үйл ажиллагаанд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга бригадын генерал Д.Ганхуяг, ЗХЖШ-ын дарга бригадын генерал С.Ганбямба, Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч бригадын генерал Ж.Болдбаатар, Батлан хамгаалахын сайдын зөвлөх, чөлөөнд байгаа дэслэгч генерал Ц.Дашзэвэг, БХЯ-ны ТЗУГ-ын дарга хурандаа Р.Энхболд нар оролцлоо.



Энэ үеэр хүндэт зочид Бүх цэргийн Их Хар сүлдэнд хүндэтгэл үзүүлж, БХЯ-ны товч танилцуулгыг сонсон дурсгалын зураг татууллаа. 1992 оны шинэ Үндсэн хууль

бол манай орны нийт хүн амыг нийгмийн анги, давхарга, үзэл бодлоор ялгаварлалгүй, нийтлэг ашиг сонирхлыг нь хамгаалж, хүн төрөлхтний хөгжлийн жам ёсыг баримтлан илэрхийлсэн ардчилсан

Үндсэн хууль болж чадсан юм.

Өөрөөр хэлбэл тус хууль нь Монгол Улсыг хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгэмд шилжин орох хууль, эрх зүйн үндсийг баттай тавьж нийгэм, улс төр, эдийн засгийн цоо шинэ орчинг бүрдүүлж, төлөвшүүлсэн. Тиймээс Монгол оронд ардчилсан хувьсгал 1990 онд ялсан хэдий ч 1992 онд шинэ Үндсэн хууль батлагдсанаар ардчилал тавьжэнэ утгаараа үндэс сууриа тавьсан билээ.

Эл түүхэн гавьяаг бүтээлцэхэд оролцсон Ардын их хурлын депутатуудад Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр хувиасаа болон Сайдын зөвлөлийн нэрийн өмнөөс талархал илэрхийлж эрүүл энх, сайн сайхныг хүсэн ерөөлөө.

Дэслэгч Т.ИДЭР

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 675,769,407

Эдгэрсэн

Нийт: 648,082,554

Нас барсан

Нийт: 6,767,601

ГАРДАН ТУЛААНЫ НАЙМАН УДААГИЙН АВАРГА ДЭСЛЭГЧ Б.НААДАМ



ҮБХИС-ийн Спорт сургалтын төвд Зэвсэгт хүчний 2023 оны гардан тулааны аварга шалгаруулах тэмцээний 85 кг жингийн алтан медалийн төлөө тоглолт явагдаж байв. Үзэгчид болон тамирчид дэлхийн хошой аваргын тоглолтыг чих, нүд тавин чимээгүй үзэж, зарим үед уухайлан алга таших нь түүний өрсөлдөгчөө "хайрлаж" тулалдаж байгаатай нь холбоотой ажээ.

Энэ бол тулааны спортын дэлхийн хошой

аварга, Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн гардан тулааны багш, ОУХМ, дэслэгч Болдбаатарын Наадамын тамирчин хүний зангаргатай үзүүштэй тоглолтод нь үзэгчид сэтгэл хангалуун байгааг илтгэнэ.

Дэслэгч Б.Наадам Зэвсэгт хүчний 2023 оны гардан тулааны аварга шалгаруулах тэмцээний 85 кг жинд ийнхүү алтан медаль авснаар 8 дахь удаагаа аваргаар тодорч, өөрийн жиндээ нэгэнт дархлагдав

бололтой.

Тоглолтын тухай сэтгэгдлийг сонирхоход "Тулаан гэдэг гэмтэл бэртэл учруулах эрсдэлтэй спорт. Миний хувьд мөрдэс нэгт нөхөдтэйгөө тулалдахдаа өөрийгөө "асааж" тоглохоос татгалздаг. Яагаад гэхээр аль аль нь гэмтэж бэртэх эрсдэл өндөр байдаг учраас зөөлөн чанараар "хайрлаж" тоглохыг эрмэлздэг. Зэвсэгт хүчинд алба хааж эхэлсэн 2011 оноос хойш энэ спортоор дагнан хичээллэж байна. Тулааны спортоор амжилт гаргаж, хичээллэх урам зоригийг өгсөн хүмүүс бол хурандаа Б.Дамба, хурандаа Д.Цог-Эрдэнэ багш.

Би заримдаа боддог. Өнөөдөр Зэвсэгт хүчинд гардан тулаанаар

хичээллэдэг залуус жилээс жилд нэмэгдэж, тэр хэмжээгээрээ өрсөлдөөн ширүүн болж байна. Миний жинд гэхэд 38 тамирчин, 60 кг жинд бүр 60 гаруй цэргийн алба хаагч байх жишээтэй. Тэгэхэд ЗХЖШ-ын Сургалт бэлтгэлийн газрын Биеийн тамир, спортын тасгийнхан зөвхөн нэг жинд 30-60 хүн бүртгүүлэхэд цааргалж, ажлаас зугтаалгүйгээр бүгдэд нь тулалдах боломж олгодог нь баярладаг. Түүнээс нэг жинд ийм олон хүн оролцуулж, зохион байгуулдаг тэмцээн манайхаас өөр хаана ч байхгүй. Энэ бол бэлтгэл сургалтаа базааж, цаг заваа гаргасан тамирчдаа бодсон хэрэг" гэв.

Дэслэгч Б.Наадам 2011-2023 онуудад Зэвсэгт хүчний гардан тулааны аваргад эхний жилүүдэд 80, сүүлийн жилүүдэд 85 кг жинд тулалдаж, тасралтгүй 8 удаа түрүүлж, улсын аварга болон тив дэлхийн уралдаанаас тэргүүлсэн нь ч тун олон.

Олон улс, тив дэлхийд эх орныхоо төрийн дууллыг эгшиглүүлж хүртсэн медаль нь гэхэд 10 гаруй гээд бод доо. Нэг жиндээ амжилтаа удаан тогтоон барих нь тамирчин бүрт амаргүй байдаг ч байнгын бэлтгэл сургалт, туршлага нь үүнд "тусалж" байдгийг тэр онцолсон. Түүний цаашдын зорилго холимог тулаанаар дэлхийд гарч, гардан тулаанаар хичээллэх цэргийн алба хаагчдад дэмжлэг үзүүлж, амжилтынх нь төлөө хамтдаа зүтгэх гэнэ лээ.

Ахмад Д.БОЛОР



ТАМИРЧИН ДАЙЧИНДАА БАЯР ХҮРГЭЛЭЭ



Зэвсэгт хүчний 2023 оны аварга шалгаруулах туухай өргөлтийн тэмцээнд Зэвсэгт хүчний 325 дугаар анги, хамт олноо төлөөлөн амжилттай оролцсон

ахлагч Б.Анхзаяад ангийн удирдлага болон нийт бие бүрэлдэхүүн баяр хүргэлээ. Ахлагч Б.Анхзаяа нь 60 килограммын жинд түлхэлтэй өргөлтөөр

75 килограммыг өргөж нэгдүгээр байр, нийлбэр дүнгээр хоёрдугаар байр эзлэн алтан медаль, спортын мастерын болзол хангасан юм.

АХЛАХ АХЛАГЧ Ж.БОЛОР-ЭРДЭНИЙН ИЛТГЭЛ ТҮРҮҮЛЛЭЭ



"Ахлагчийн манлайлал-цэргийн сургалт бэлтгэлд нөлөөлөх нь" сэдэвт Зэвсэгт хүчний ахлагчийн бүрэлдэхүүний эрдэм шинжилгээний хурлын хүрээнд зохион байгуулсан илтгэлийн тэмцээнд Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн хүний нөөцийн хэрэг хөтөлөгч ахлах ахлагч Ж.Болор-Эрдэнэ "Байлдааны жижүүрлэлтэд үүрэг гүйцэтгэдэг ахлагч нарын тулгамдаж буй асуудлууд, шийдвэрлэх арга зам" сэдвээр илтгэл танилцуулж тэргүүн байрыг эзэллээ.



"УГСААТАН" БАГ ТЭРГҮҮН БАЙР ЭЗЭЛЛЭЭ



Зэвсэгт хүчний 353 дугаар ангийн Суртал соёл хүмүүжил, сэтгэлзүйн албанаас үндэсний өв соёл, дуу хуур, тоглоом наадгай, түүх шаштир, утга зохиол, бичиг соёлын өв уламжлалаа түгээн дэлгэрүүлэх, сурталчлан таниулах зорилгоор "Цагаан сар Монгол түмний их баяр" тэмцээнийг

алба, салбаруудынхаа дунд зохион байгууллаа. Тэмцээнд дөрвөн баг оролцож мэндчилгээ, заавал дуулах дуу, АХА, "Дэмбээ" наадгай, Халх ардын дуугэсэн таван төрлөөр өрсөлдсөнөөс тэргүүн байрт 323 дугаар дивизоны "Угсаатан" баг, дэд байрт Хорооны командын байрын "Үндэстэн" баг удаах

байруудад "Үлээвэр найрал хөгжим", 324 дүгээр дивизоны баг шалгарлаа. Тус тэмцээн нь Зэвсэгт хүчний Жанжин штабаас зохион байгуулах "Цагаан сар-Монгол түмний уламжлалт их баяр"-т оролцох бүрэлдэхүүнийг сонгон шалгаруулахад чиглэсэн юм.

ГАРДАН ТУЛААНЫ АВАРГА ЖОЛООЧ БҮСГҮЙ



Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн аэродром үйлчилгээний ротын жолооч ахлагч М.Дөлгөөн Зэвсэгт хүчний аварга шалгаруулах гардан тулааны тэмцээний 60 кг-ын жинд тэсвэр хатуужил, ур чадвараа дайчлан өрсөлдөж, 5 удаагийн тоглолтод техникийн давуу байдлаар илт давамгай ялалтыг байгуулан алтан медаль хүртлээ.

